

## ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ГАЗРЫН 2018 ОНЫ 08 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 08 дугаар сарын 26

Замын-Үүд сум

Тус газар нь Монгол улс, Олон улсын хэлэлцээр, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Боомтын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145, 339, 146 дугаар тогтоол, Засгийн газрын 2010 оны 338, 339, 340 журам тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актууд, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал, албан даалгаврыг тус тус удирдлага болгон гадаадын иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилэхэд анхаарч 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 2018 оны 08 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1 Монгол Улсын виз, зөвшөөрөл, хяналт шалгалтын талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолыг тус тус үндэслэн виз олгохыг хүссэн 12 орны 90 иргэнд зохих зориулалт ангиллын визийг олгож, визийн хураамж болох 4,660.500 төгрөг, визийн үнэ болох 352,500 төгрөгийг Төрийн сангийн зохих дансанд нь төвлөрүүлэн ажилласан.

Үүнд:

- Нэг удаагийн орох – 13 иргэн
- Нэг удаагийн гарах, орох – 30 иргэн
- Визийн шилжүүлэг – 3 иргэн
- Нэг удаагийн дамжин өнгөрөх – 1 иргэн
- Алдаатай олгосон виз засварлан – 43

1.2 Хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын иргэдийн талаар:

Боомт, орон нутгийн хэлтсийн даргын 2017.05.26-ны өдрийн 11/2092 тоотыг үндэслэн хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын 1439 иргэн /давхардсан тоогоор/ -ний хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавьж ажилласан.

1.3. Алдаатай визийн талаар:

Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаас алдаатай олгогдсон БНХАУ-ын-35, Бүгд найрамдах Азербайжан-1, Бүгд найрамдах Исланд-2, БНФинлянд-1, БНФУ-1, Испани-1, Мексик-1 иргэний визийг илрүүлэн, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

1.4. Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар:

БНХАУ-ын 36 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч, мэдээллийг нь зохих хугацаанд Төвд хүргүүлж ажилласан.

1.5 Түр ирэгч бүртгэлийн талаар:

АНУ-5, БНФУ-1, Израйль-2, БНХАУ-25 иргэн нийт 33 иргэнг түр ирэгчээр бүртгэн, бүртгэлийн хураамж болох 64,000 төгрөгийг зохих дансанд тушааж ажилласан.

1.6. Хасалт хийсэн талаар:

Насанд хүрээгүй тул торгуулиас чөлөөлөгдөн бүртгэлд хасалт хийлгэсэн АНУ-2, зөрчил гарган арга хэмжээ авагдсан БНХАУ-ын 24, Израйль-2, БНФУ-1 иргэн, оршин суух

зөвшөөрөлд уригчийн хүсэлтээр хасалт хийж, ОСЗ хураалгасан БНХАУ-ын 128 иргэн , нийт гадаадын 4 орны 157 иргэнд хасалт хийж, Монгол улсаас гаргасан болоно.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн талаар:

Тайлант хугацаанд Дорноговь аймаг дахь газрын дарга 1 тушаал батлан гаргасан ба үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээ, тус газрын сар бүрийн үйл ажиллагааны тайланг гаргаж Боомт, орон нутгийн газарт хэлтэст тус тус хүргүүлэн ажиллаж байна.

2.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар

Дорноговь аймаг дахь газар нь албан хэрэг хөтлөлтийн ажилладаг “Хяналтын карт”, ирсэн бичиг, өргөдөл, гомдолд “Бүртгэл хяналтын карт”-ыг тухай бүр хөтөлдөг ба хариутай албан бичгийг стандартын дагуу боловсруулдаг болно.

Тайлант хугацаанд тус газрын бичиг хэрэгт 2 албан бичиг ирснийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 1 албан бичгийн хариуг өгч, 7 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Албан хаагчдаас чөлөө хүссэн 2 өргөдөл ирснийг 1-ийг төв газарт шилжүүлж шийдвэрлүүлсэн.

Харин тус газарт ирсэн гомдол байхгүй болно.

Хамтран ажиллагч байгууллагад Дорноговь аймаг дахь газрын албан хаагчдын сахилга хариуцлага, ес зүйн талаар болон манай байгууллагаас цаашид хэрэгжүүлэн ажиллах санал хүсэлт, зөвлөмж хүлээн авах ” Санал хүсэлтийн дэвтэр”-ийг нээж, ажиллуулж эхэлсэн.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар

Байгууллагын бүтэц, зохион байгуулалтад 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдөр өөрчлөлт орсонтой холбогдуулан ГИХГ-ын даргын энэ оны Б/51 дүгээр тушаалаар тус газрын батлагдсан орон тоо 28 бөгөөд бүртгэлтэй байгаа 24 албан хаагчаас 23 албан хаагч ажиллаж байна. Үүнээс хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагч байна.

ГИХГ-ын даргын 2018 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн Б/216 тоот тушаалаар мэргэжилтэн Г.Буяннямд эрүүл мэндийн байдлыг үндэслэн 15 хоногийн цалинтай чөлөө, 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн Б/217 тоот тушаалаар Чулуунбаатар овогтой Баярсайханг жолоочоор, 2018 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн Б/231 тоот тушаалаар Энхсайханы Чинзоригийг мэргэжилтнээр, 2018 оны 08 дугаар сарын 21-ны өдрийн Б/234 тоот тушаалаар Дашдаваагийн Хоролсүрэн сүлжээний инженерээр тус тус томилогдон ажиллаж байна.

2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар

Тайлант хугацаанд батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 35,981.1 мянган төгрөгийн санхүүжилт орсноор 31,251,6 мянган төгрөгний зарлага гаргасан. Үүнээс цалин хөлс 22,396.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 3,143.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 5,712.1 мянган төгрөгийг зарцуулан ажилласан.

Гурав. Бусад

Дотоод нөөц бололцоогоо ашиглан Ханги боомтын албаны өрөөнд бүрэн засвар үйлчилгээ, байгууллагын 103 тоот өрөө болон газрын даргын өрөөний дотоод засвар, Сайншанд төлөөллийн газарт ажлын байрны тохижилт, автомашины грашид дулааны шугам шинээр татах сантехникийн угсралтын ажил, албаны байрны 2 болон 3 давхрын гэрэлтүүлэг шинэчлэн солих, байгууллагын гадна ар талд шинээр барьсан саравчны өнгө үзэмжийг сайжруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Ханги боомтын ажлын өрөөнд бүрэн засвар  
/ хана, тааз, шал/




Ханги боомтод чанга яригч узель хүлээлгэн өгөв




Сайншанд дахь газрын ажлын байрны тохижилт



103 тоот өрөө, Даргын өрөө засвар




Автомашины грашид дулааны шугам шинээр татах  
сантехникийн угсралтын ажил



Албаны байрны 2 болон 3 давхрын гэрэлтүүлэг



Шинээр барьсан саравчны өнгө үзэмжийг сайжруулав



380 вт-ын Цахилгаан кабелийн утас шалбарсныг илрүүлэн,  
цахилгаан шугам хоолойг утсыг засварлаж янзалсан.

